ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 06 сарын 08 өдөр Дугаар А/100 Хужирт сум

## Хамгаалалтын бүс тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн 2.2, 2.4 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, засвар үйлчилгээг саадгүй явуулах, хүн, амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрдэнэт-Булган Цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компаний эзэмшлийн 35/10/0,4/0,22кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10,10/0,4кВ-ын дэд станцын хамгаалалтын зурвасыг хавсралтаар тогтоосугай.

2. Хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж, орон сууц, гэр хашаа барих, эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн горим, ажиллагааг алдагдуулах үйл ажиллагаа явуулахыг хориглосугай.

3. Хамгаалалтын зурваст дэглэм сахиулах, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах ажлыг хариуцан ажиллахыг Эрчим хүчний эрхлэгч (Ж.Мандах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100193

Сумын Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 08. –ны өдрийн А/100 дугаар захирамжийн хавсралт

Хамгаалалтын зурвас

| № | Шугам сүлжээний ангилал | Хамгаалалтын зурвасын хэмжээ | |
|---|---|---|---|
| | | Цахилгаан дамжуулах агаарын шугам | Дэд станц |
| | | Шугамын захын утаснаас хоёр тийш | Тал бүр тийш |
| 1 | 1-20 хүртэл кВ | 2 метр | 10 метр |
| 2 | 35кВ | 4 метр | 15 метр |

-oOo-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 06 сарын 16 өдөр Дугаар А/101 Хужирт сум

Урамшуулал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2013 оны А/406 дугаар захирамжаар батлагдсан “Төсвийн ерөнхий болон шууд захирагч нарын ажлын үр дүнг үнэлж, дүгнэх” журам, 2020 оны “Хариуцлага тооцох, шагнал, урамшуулал олгох тухай” А/344 дүгээр захирамжийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны төсөв санхүүгийн сахилга бат, хариуцлага, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг харгалзан Засаг даргын Тамгын газрын дарга, 1, 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч, Соёлын төвийн эрхлэгч, нягтлан бодогчид, Төрийн сангийн мэргэжилтэн нарт олгох урамшууллын хэмжээг хавсралтаар батлагсугай.

2. Урамшууллыг тогтоосон хэмжээгээр тухайн байгууллагын төсвөөс олгохыг байгууллагууд хариуцсан нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй .

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2020 оны 06
дугаар сарын 16 өдрийн А/101 дугаар
захирамжийн хавсралт

# ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ, НЯГТЛАН БОДОГЧ НАР, ТӨРИЙН САНГИЙН МЭРГЭЖИЛТЭНД ОЛГОХ УРАМШУУЛАЛ

(үндсэн цалингийн)

| Д/Д | Байгууллагын нэр | Дарга, Эрхлэгч | Нягтлан бодогч |
|---|---|---|---|
| 1 | 1 дүгээр Цэцэрлэг | 1 сарын | 0,5 сарын |
| 2 | 2 дугаар Цэцэрлэг | 1 сарын | 0,5 сарын |
| 3 | Засаг даргын Тамгын газар | 1 сарын | 1 сарын |
| 4 | Соёлын төв | 1 сарын | 1 сарын |
| 5 | Төрийн сангийн мэргэжилтэн | 0,5 сарын | |

-oOo-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 06 сарын 17 өдөр Дугаар А/102 Хужирт сум

Архи согтууруулах ундаа худалдаалах,
түүгээр үйлчлэхийг түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 (а), (ж), Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, 70.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль явагдахтай холбогдуулан 2020 оны 6 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг, 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдөр хүнс, барааны дэлгүүр болон архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийг ажиллахыг түр хориглосугай.

2. Дээрх захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Оюунгэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250180203

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 26 өдөр Дугаар А/56 Хужирт сум

Итгэмжлэгчээр томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 3 дугаар багийн иргэн Жамбалын Долгормаа (ЙС10301005) нь 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдөр өвчний улмаас нас барсан бөгөөд оршуулгын ажлыг хариуцах итгэмжлэгдсэн этгээдээр ээж Бадамсамбуугийн Хандсүрэнг (ЙС90011905) томилсугай.

2. Холбогдох баримт бичгийг бүрдүүлэн оршуулгын тэтгэмжинд хамруулахыг нийгмийн халамжийн сум хариуцсан мэргэжилтэн (Ё.Даариймаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100111

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 27 өдөр Дугаар А/57 Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Зорилтот жил болгон зарлах тухай” 12/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өвөрхангайд үйлдвэрлэв” зорилтот жилийн ажлын хэсгийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Мөнхбат-Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: Б.Доржсэмбэ-Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд: Д.Уранчимэг-Санхүүгийн албаны дарга
Ё.Даариймаа-Халамжийн сум хариуцсан мэргэжилтэн
Т.Энхжаргал-Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн
С.Самдан-Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
Т.Элбэгсайхан-Архив, бичиг хэргийн эрхлэгч
Б.Пагамдулам-1 дүгээр багийн Засаг дарга
Д.Батбаян-2 дугаар багийн Засаг дарга
Д.Галиндэв-3 дугаар багийн Засаг дарга
Д.Батбаяр-4 дүгээр багийн Засаг дарга
Ц.Лхамролом-5 дугаар багийн Засаг дарга
Ц.Амгалан-6 дугаар багийн Засаг дарга
О.Баярманлай- “Жем Хужирт” ХХК-ний хүний нөөцийн менежер

2. Зорилтот жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Мөнхбат)-д даалгайсугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100113

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 27 өдөр Дугаар А/58 Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай, Арвайхээр, 5 дугаар баг, хангамж, 24 орон сууц байр, 16 тоот хаягт оршин суугч Чойгүнсэнгийн Хүрэлбаатар (АЮ64121871) нь өөрийн эзэмшлийн 4 дүгээр баг Шивээт 19 тоотод байрлах 0279751 тоот гэрчилгээний дугаартай, 6211000310 тоот нэгж талбарын дугаартай “Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор”-ын зориулалттай 623.0 м2 газрыг Тус сумын 2 дугаар баг Уужим хаягт байрлах Дагиймаагийн Цэвэлмаа (ЙС78102001)-ийн эзэмшилд шилжүүлсэн тул дээрх газрыг Дагиймаагийн Цэвэлмаа (ЙС78102001)-д “Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор”-ын зориулалтаар 47 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 16 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100115

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 30 өдөр Дугаар А/59 Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шунхлай 5 дугаар баг Гуа 64 тоотод байрлах Намхайдоржийн Чинбат (ЙС73040137)–ын эзэмшлийн 0011195 гэрчилгээний дугаартай, 6211000292 тоот нэгж талбарын дугаартай үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай 0,3283 $м^2$ газрын эзэмших эрхийг 40 жилийн хугацаатайгаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100117

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр    Дугаар А/60    Хужирт сум

## Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 102 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны “Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай” А/138 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 102 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан сумын хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгасугай.

2. Хүнсний дэлгүүр болон архи, согтууруулах ундаа түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийн ажиллах цагийг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл оройн $20^{00}$ цаг байхаар хязгаарлалт тогтоон өөрчилж, караоке, баар, цэнгээний газруудын үйл ажиллагааг дээрх хугацаанд түр зогсоосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/30 дугаар захирамжийн 3 дахь заалт, 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай” А/39 дүгээр захирамжийг тус тус хүчингүй болгосугай.

4. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, хошууч (Х.Түмэнбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА    Т.БАЯРМӨНХ

250100119

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**

**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 01 өдөр Дугаар А/61 Хужирт сум

## Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын "Газар өмчлүүлэх тухай" 2005 оны 88 дугаар захирамжийн хавсралтын 62, 2006 оны 17 дугаар захирамжийн хавсралтын 54 дугаарт байгаа 2 өрхийн нэр бүхий 9 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250190131

Хужирт сумын Засаг даргын 2020 оны
04 дугаар сарын 01 -ны өдрийн А/61 дугаар
захирамжийн хавсралт

Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

| өрхийн дугаар | Д/д | Өмчлөгчийн | | | | | | Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо | Газрын | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Овог | Эцэг /эх/-ийн нэр | Өөрийн нэр | Оршин суугаа хаяг | Регистр | 16 нас хүрээгүй өмчлөгчийн гэрчилгээний дугаар | | Байршил | Хэмжээ /м2/ | Газрын үнэ /мян.төг/ |
| А | 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 62 | 1 | Хумбага | Эрдэнэцэцэг | Даваанoров | 3-р баг | ЙС02242817 | | 2005.09.12<br>38 | 5-р баг 815 тоот | 837 | 16740 |
| | 2 | Умбаг | Эрдэнэцэцэг | Мягмарсүрэн | 3-р баг | ЙС90112728 | | | | | |
| 43 | 3 | Боржигин | Сампил | Отгонбат | 2-р баг | ЙС67041810 | | 2006.02.28<br>17 | 5-р баг | 1118 | 22360 |
| | 4 | Равжир | Сүх | Шаравдорж | 2-р баг | ЙС69013024 | | | | | |
| | 5 | Дайчин | Отгонбат | Энх-Амгалан | УБ.СХД | ЙС89012207 | | | | | |
| | 6 | Дайчин | Отгонбат | Мөнххишиг | 2-р баг | ЙС90072212 | | | | | |
| | 7 | Боржигин | Отгонбат | Мягмарбаяр | УБ.СХД | ЙС95123104 | | | | | |

o0o

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 02 өдөр Дугаар А/62 Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 6/4/01 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангаас малжуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2013, 2014 оны малжуулах төсөлд хамрагдан зээлээ бүрэн төлөөгүй, зээлийн хугацаа хэтэрсэн малчдын зээлийн эргэн төлөлтийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Оюунгэрэл-Засаг даргын орлогч
Гишүүн: Д.Уранчимэг - Санхүүгийн албаны дарга
Г.Оюунмандах - Нягтлан бодогч
С.Самдан – Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
Б.Доржсэмбэ – Бэлчээр, газарт тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Б.Пагамдулам - 1 дүгээр багийн Засаг дарга
Д.Батбаян - 2 дугаар багийн Засаг дарга
Д.Галиндэв - 3 дугаар багийн Засаг дарга
Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга
Ц.Лхамролом - 5 дугаар багийн Засаг дарга
Ц.Амгалан - 6 дугаар багийн Засаг дарга

2. Эргэн төлөлтийг төвлөрүүлэх ажлыг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны дотор үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501001 3

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 02 өдөр Дугаар А/63 Хужирт сум

Сумын онцгой комиссын бүрэлдэхүүн, журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын онцгой комиссын ажиллах журам”-ын 1.3 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, онцгой комисс ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх хор уршгийг арилгах, аврах, хойшлуулашгүй сэргээн босгох арга хэмжээнд онцгой комисс ажиллах журам болон энэ талаар даган мөрдөж байгаа бусад хууль тогтоомжуудтай нийцүүлж шуурхай зохион байгуулж ажиллахыг комисс, бие бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавиж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/22 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100125

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 03 өдөр Дугаар А/64 Хужирт сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020 оны "Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай" А/89 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархсан Өвөрмодот, Уужим, Бэрх, Шивээт, Шунхлай, Дулаан багийн нийт 6000 га бэлчээрт микробиологийн аргаар мэрэгчтэй тэмцэх ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажил зохион байгуулагдахтай холбогдуулан дээрх багуудийн бэлчээрийн талбайг 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд чөлөөлсүгэй.

4. Чөлөөлөгдсөн бэлчээрт мал оруулахгүй байх талаар малчдад мэдээлэл хүргэж ажиллахыг багийн Засаг дарга, иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт, малаа тухайн чөлөөлөгдсөн бэлчээрт оруулахгүй байхыг малчдад тус тус үүрэг болгосугай.

5. Мэрэгчтэй тэмцэх ажилд малчид, малчны бүлэг, хоршооны гишүүдийг хамруулах, тэднийг мэрэгч устгалын гарын авлага, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр ханган сургалт зохион байгуулж, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэх, богино хугацаанд бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэг (Ж.Оюунгэрэл)-д үүрэг болгосугай.

6. Мэрэгчтэй тэмцэх ажлын явц, үр дүн, чанарт хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (З.Цэцэгмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100127

Сумын Засаг даргын 2020 оны 01 дугаар
сарын 03 –ны өдрийн А/57 дугаар
захирамжийн хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Оюунгэрэл - Засаг даргын Орлогч
Нарийн бичгийн дарга: Б.Доржсэмбэ- Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
Гишүүд: С.Самдан – Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
Т.Энхжаргал – Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Ц.Нямдорж - Газрын даамал
Ч.Сонинбаяр - Байгаль хамгаалагч
Б.Пагамдулам - 1 дүгээр багийн Засаг дарга
Д.Батбаян - 2 дугаар багийн Засаг дарга
Д.Галиндэв - 3 дугаар багийн Засаг дарга
Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга
Ц.Лхамролом - 5 дугаар багийн Засаг дарга
Ц.Амгалан - 6 дугаар багийн Засаг дарга

-оОо-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 03 өдөр | Дугаар А/65 | Хужирт сум

Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны "Мэргэжлийн ангийн дүрэм шинэчлэн батлах тухай" 75 дугаар тушаалын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангиудыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Гамшгаас хамгаалах сумын мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлж, бүтэц зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг чиглэлийг тодорхойлон, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Мөнхбат)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн "Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай" А/21 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250190129

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 07 өдөр Дугаар А/66 Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дугээр зүйлийн 30.1, 52 дугаар зүйлийн 52.7 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хавсралтанд дурьдсан нэр бүхий 4 иргэнд өвөлжөө хаваржааны доорхи газрыг 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100131

Хужирт сумын Засаг даргын 2020 оны
04 дүгээр сарын 07-ний өдрийн А/66
дугаар захирамжийн хавсралт

Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг шинээр эзэмших иргэдийн нэрсийн жагсаалт

| д/д | Газар эзэмшигчийн | | | Эзэмшсэн газрын | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эцэг /эх/-ийн нэр | Өөрийн нэр | Регистрийн дугаар | Багийн нэр, дугаар | Хаяг, байршил, газар зүйн нэр | Зориулалт | Хэмжээ /м²/ | Газар зүйн солбицол |
| 1 | Дамбий | Дагва-Очир | ЙС98122216 | Өвөр модот 1-р баг | Таван булгийн тархи | Хаваржаа | 700 | 5188191,46 336445,27 |
| 2 | Чулуун | Цолмон | ЙС87052416 | Шунхлай 5-р баг | Цагаан хошууны өвөрт | Хаваржаа | 700 | 5186232,16 328510,58 |
| 3 | Болд | Төмөрчөдөр | ЙС94091535 | Уужим 2-р баг | Нарийн Цувьрайн Улаан хад | Өвөлжөө | 700 | 5182735,33 321893,11 |
| 4 | Ваашаа | Батсайхан | ЙС76022813 | Дулаан 6-р баг | Дулааны Бунхант | Өвөлжөө | 700 | 51922315,11 355384,93 |

-oOo-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 07 өдөр Дугаар А/67 Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх " Нохой устгал ӨВХУСЗДТГ/202001013" ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Самдан - Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд: Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга
Ч.Сонинбаяр - Байгаль хамгаалагч

2. Гэрээ шууд байгуулах ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг Ажлын хэсэг (С.Самдан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100123

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 07 өдөр Дугаар А/68 Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумаас гадны аймаг, сумдад оторлож буй малчдад олгох 500 шуудай нүүрс тээвэрлэж ирэх зардалд 500000 (таван зуун мянга) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100135

Сумын Засаг даргын 2020 оны
04 дүгээр сарын 07-ны өдрийн А/68
дугаар захирамжийн хавсралт

| № | Зардлын төрөл | Нэгжийн тоо | Нэгжэд ноогдох мөнгөн дүн | Нийт мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Тээврэлтийн зардал | 1 | 500.000 | 500.000 |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 07 өдөр Дугаар А/69 Хужирт сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын "Хог хаягдлын нэгдсэн цэгийн хогийг түрж, цэгцлэх ӨВАХУСЗДТГ/202001011" ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Мөнхбат - Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд: З.Цэцэгмаа - Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
Ч.Сонинбаяр - Байгаль хамгаалагч
О.Алтанчимэг - Байгаль хамгаалагч
Ц.Нямдорж - Газрын даамал

2. Гэрээ шууд байгуулах ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100137

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 10 өдөр | Дугаар А/70 | Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн, Арвайхээр сумын, 5 дугаар баг, Арвайхээр 1 гудамж, 15 тоот хаягт оршин суугч Нарангийн Өлзийбадрах (ЙЮ87102511) нь өөрийн эзэмшлийн 5 дугаар баг Гуа 68 тоотод байрлах 000642970 гэрчилгээний дугаартай, 6211003011 нэгж талбарын дугаартай "Худалдаа, үйлчилгээний газар"-ын зориулалттай 2000.0 м$^2$ газрыг Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 12 дугаар хороо, 6 бичил хороолол, Хасбаатар гудамж, 6а байр 28 тоот хаягт байрлах Самданцоодолын Ганбаяр (ШД87051894)-ын эзэмшилд шилжүүлсэн тул дээрх газрыг Самданцоодолын Ганбаяр (ШД87051894)-т "Худалдаа, үйлчилгээний газар"-ын зориулалтаар 27 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2017 оны 04 дугаар сарын 11-ний өдрийн "Газар эзэмших эрх шинээр олгох тухай" А/43 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100139

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 13 өдөр Дугаар А/71 Хужирт сум

Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл
сунгах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" 07/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд тамхины худалдаа эрхэлж буй Цэзтаяагийн Долгорын (ЙС75062424) "Ундрам" дэлгүүрийн тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлийн хугацааг сунгасугай.

2. Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга (Х.Түмэнбаяр), Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн (С.Самдан) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 13 өдөр Дугаар А/72 Хужирт сум

Итгэмжлэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Уужим 2 дугаар багийн иргэн Алтанцэцэгийн Дэчмаа (ЙС09281520) нь хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаанд байдаг тул түүний итгэмжлэгчээр эмээ Цэдэнсодномын Долгормааг (ЙС64061608) томилсугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100143

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 13 өдөр Дугаар А/73 Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 4 дүгээр зөвлөмжөөр Эрүүл мэндийн төвийн эмчилгээний хоолны хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ӨВАХУСЗДТГ202001009" тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул тендерийг тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар дахин зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Ж.Шижээ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100145

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 14 өдөр Дугаар А/74 Хужирт сум

Тендер хүчингүй болгож,
шууд гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 02 дугаар зөвлөмжөөр 2 дугаар Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ӨВАХУСЗДТГ202001002” тендерийн 2 дугаар багц Сүү, сүүн бүтээгдэхүүн багцыг хүчингүй болгосугай.

2. Дээрх багцад нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулахыг 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч (Ш.Эрдэнэхорол)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250190147

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 16 өдөр Дугаар А/75 Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх " Нохой устгал ӨВХУСЗДТГ/202001013" ажлыг хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Шижээ - "Хужирт эрдэс" ОНӨААТҮГ-ын дарга
Гишүүд: Ц.Амгалан - 6 дугаар багийн Засаг дарга
Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга

2. Дээрх ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу хүлээж авахыг ажлын хэсэг (Ж.Шижээ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100142

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 17 өдөр Дугаар А/76 Хужирт сум

Зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай" А/150 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын нэр бүхий 2 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг хавсралтаар олгосугай.

2. Албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож Засаг даргын Тамгын газрын цалингийн сангаас олгохыг нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100151

Сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр
сарын 17 - ны өдрийн а/26 дугаар
захирамжийн хавсралт

Зэрэг дэвийн нэмэгдэл

| № | Албан хаагчийн нэр | Албан тушаал | Зэрэг дэв | Зэргийн нэмэгдэл |
|---|---|---|---|---|
| 1 | Дамдингийн Уранчимэг | Санхүүгийн албан дарга | Дэс түшмэлийн дэтгээр | 18% |
| 2 | Тэрбишийн Энхжаргал | Хөдөлмөрийн ажилтан | Туслах түшмэлийн тэргүүн | 16% |

oOo

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 22 өдөр  Дугаар А/77  Хужирт сум

Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл
сунгах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Журам шинэчлэн батлах тухай” 07/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд тамхины худалдаа эрхэлж буй Гомбын Булганчимэг (ЧД60111201) “Өвгөн Шунхлай” дэлгүүрийн тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасугай.

2. Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга (Х.Түмэнбаяр), Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн (С.Самдан) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Т.БАЯРМӨНХ

250120153

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 22 өдөр    Дугаар А/78    Хужирт сум

Тендер хүчингүй болгож,
шууд гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 02 дугаар зөвлөмжөөр 1 дүгээр Цэцэрлэгийн хүүхдийн хоолны хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ӨВАХУСЗДТГ202001001" тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулахыг 1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч (З.Оюунчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА    Т.БАЯРМӨНХ

250100155

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 28 өдөр Дугаар А/79 Хужирт сум

Харгалзан дэмжигчээр тогтоох тухай

Гэр бүлийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1, 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Өвөрмодот 1 дүгээр багийн иргэн Отгончимэгийн Цэнд-Очир (ЙС06222415) хүүгийн харгалзан дэмжигчээр түүний нагац эгч тус сумын Өвөрмодот 1 дүгээр багийн иргэн Цагаалайн Эрдэнэцэцэгийг (ЙС60011721) тогтоосугай.

2. Холбогдох баримт бичгийг бүрдэл болгож тэтгэмжинд хамруулахыг Нийгмийн халамжийн сум хариуцсан мэргэжилтэн (Ё.Даариймаа), харгалзан дэмжих үүрэгт хяналт тавьж ажиллахыг Өвөрмодот 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Пагамдулам) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100157

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 28 өдөр Дугаар А/80 Хужирт сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 (а) дахь заалт, Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам"- ын 2.2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Багийн ахлагч: Д.Мөнхбат - Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд: Б.Пагамдулам - 1 дүгээр багийн Засаг дарга
Д.Батбаян - 2 дугаар багийн Засаг дарга
Д.Галиндэв - 3 дугаар багийн Засаг дарга
Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга
Ц.Лхамролом - 5 дугаар багийн Засаг дарга
Ц.Амгалан - 6 дугаар багийн Засаг дарга
С.Самдан - Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
Т.Элбэгсайхан - Архив, бичгийн эрхлэгч
О.Алтанчимэг - Байгаль хамгаалагч
Ч.Сонинбаяр - Байгаль хамгаалагч
Т.Сундуйбаяр - Тархвар зүйч
С.Тунгалаг - Цаг уурын станцын эрхлэгч

2. Холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу гамшгийн эрсдлийн тойм судалгааг үр дүнтэй хийхийг ажлын хэсэг, тайлан мэдээг холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Мөнхбат)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250190159

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**

**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 29 өдөр Дугаар А/81 Хужирт сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 (а) дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх жагсаалт гаргах удирдамжийн төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Мөнхбат- Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга: Р.Ариунбаатар - Улсын бүртгэгч
Нарийн бичгийн дарга: Ц.Нямдорж - Газрын даамал
Гишүүд: Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга
Ц.Лхамролом - 5 дугаар багийн Засаг дарга

2. Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх жагсаалт гаргах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсэгт, хэрэгжүүлсэн ажлын тайланг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэхийг нарийн бичгийн дарга (Ц.Нямдорж), Удирдамжийг хэрэгжүүлэх явцад гарсан алдаа, дутагдлын талаарх саналыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (Д.Мөнхбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100161

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 29 өдөр Дугаар А/82 Хужирт сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020 оны “Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” А/149 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч тархсан Өвөрмодот багийн 8750 га бэлчээрт энгийн механик биологийн аргаар мэрэгчтэй тэмцэх ажлыг 2020 оны 05 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2. Мэрэгчтэй тэмцэх ажилд малчид, малчны бүлэг, хоршооны гишүүдийг хамруулах, тэднийг мэрэгч устгалын гарын авлага, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр ханган сургалт зохион байгуулж, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэх, богино хугацаанд бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэг (Д.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

3. Мэрэгчтэй тэмцэх ажлын явц, үр дүн, чанарт хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (З.Цэцэгмаа), ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг заавар журмын дагуу гаргаж 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хүнс, Хөдөө Аж ахуйн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Мөнхбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100163

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 30 өдөр Дугаар А/84 Хужирт сум

## Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг дахин сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 147 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 147 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан сумын хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасугай.

2. Хүнсний дэлгүүр болон архи, согтууруулах ундаа түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл оройн $20^{00}$ цаг байхаар хязгаарлалт тогтоон өөрчилж, караоке, баар, цэнгээний газруудын үйл ажиллагааг дээрх хугацаанд түр зогсоосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай” А/60 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

4. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100167

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 04 өдөр　　　Дугаар А/85　　　Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 4 дүгээр баг Шивээт 61 тоотод байрлах Дэнсмаагийн Түвшинжаргал (ЙС73011007) –ын эзэмшлийн 0023631 тоот гэрчилгээний дугаартай, 6211000293 нэгж талбарын дугаартай эмчилгээ, үйлчилгээний зориулалттай 500 $м^2$ газрын эзэмших эрхийг 40 жилийн хугацаатайгаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА　　　Т.БАЯРМӨНХ

250100169

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 04 өдөр | Дугаар А/86 | Хужирт сум

## Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

"Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын "Газар өмчлүүлэх тухай" 2005 оны 88 дугаар захирамжийн хавсралтын 148, 2006 оны 17 дугаар захирамжийн хавсралтын 77 дугаарт байгаа 2 өрхийн нэр бүхий 7 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100171

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 11 өдөр Дугаар А/87 Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 , 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Соёлын төвийн тохижилт” тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Л.Цэдэв-Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: О.Алтанчимэг-Байгаль хамгаалагч
Гишүүд: Д.Уранчимэг-Санхүүгийн албаны дарга
З.Цэцэгмаа-Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
Ж.Шижээ-Иргэний төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Л.Цэдэв)-т даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (О.Алтанчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100173

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 11 өдөр Дугаар А/88 Хужирт сум

Тендер хүчингүй болгож,
шууд гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3, 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар зөвлөмжөөр Эрүүл мэндийн төвийн эмчилгээний хоолны хүнсний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ӨВАХУСЗДТГ202001009” тендерийг хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерт нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Ц.Ундрахбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100175

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 15 өдөр Дугаар А/89 Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2 дугаар баг, Уужим хаягт оршин суух Дашийн Гэрэл (ЙС68080116) нь өөрийн эзэмшлийн 5 дугаар баг Гуа 65 тоотод байрлах 000004900 гэрчилгээний дугаартай, 6211000317 нэгж талбарын дугаартай "Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор"-ын зориулалттай 4000.0 $м^2$ газраас 2250 $м^2$ газрыг тус сумын 4 дүгээр баг, Шивээт 11-286 тоот хаягт оршин суух Ооёогийн Баярманлайгийн (УП89041121) эзэмшилд шилжүүлсэн тул дээрх газрыг Ооёогийн Баярманлайд (УП89041121) "Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор"-ын зориулалтаар 52 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2012 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 57 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100177

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 15 өдөр Дугаар А/90 Хужирт сум

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5.1, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Соёлын төвийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Соёлын төвийн эрхлэгч (О.Долгормаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100179

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 20 өдөр Дугаар А/91 Хужирт сум

Хагас жилийн малын түүвэр судалгаа авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 (г), Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 (в) дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2020 оны хагас жилийн малын түүвэр судалгааны ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Оюунгэрэл - Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: С.Самдан - Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд: Г.Оюунмандах - Нягтлан бодогч
Б.Пагамдулам - 1 дүгээр багийн засаг дарга
Д.Батбаян - 2 дугаар багийн Засаг дарга
Д.Галиндэв - 3 дугаар багийн Засаг дарга
Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга
Ц.Лхамролом - 5 дугаар багийн Засаг дарга
Ц.Амгалан - 6 дугаар багийн Засаг дарга

2. Хагас жилийн малын түүвэр судалгааны ажлыг батлагдсан удирдамж, графикийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Оюунгэрэл), нэгдсэн дүн мэдээг 06 дугаар сарын 05-ны дотор холбогдох газарт хүргүүлэхийг нарийн бичгийн дарга (С.Самдан) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100181

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 12 өдөр Дугаар А/92 Хужирт сум

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 (а) дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох төслийг суманд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн ахлагч: Д.Мөнхбат - Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: А.Гантулга - Ерөнхий боловсролын сургуулийн захирал
Гишүүд: Б.Цэрэнноров - Насан туршийн боловсролын арга зүйч
Т.Энхжаргал - Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Д.Жавзандолгор- Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Б.Доржсэмбэ-Газар тариалан, бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Т.Даваамаа- Багш
Пүрэвсүрэн-Эцэг, эхийн төлөөлөл-
Д.Мягмарсүрэн-Сайн дурын төлөөлөл
П.Мөнхдалай-Бизнес эрхлэгч
Т.Хангал-Өсвөр үе, залуучуудын төлөөлөл

2. Төслийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг зөвлөл (Д.Мөнхбат)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100183

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 20 өдөр Дугаар А/93 Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 (а) дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 167 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Оюунгэрэл - Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: Ё.Даариймаа - Нийгмийн халамжийн ажилтан
Гишүүд: Л.Цэдэв - Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн
Т.Энхжаргал - Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн
С.Самдан - Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх үеэр бараа бүтээгдэхүүний нэр төрөл цөөн байх, хугацаа дууссан бүтээгдэхүүн борлуулах, барааны үнийн зохимол өсөлт бий болгох, ахуйн бараа болон архи согтууруулах ундаагаар үйлчилж байгаа зэрэгт 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хуртэлх хугацаанд хяналт шалгалт хийж, зөрчил илэрсэн тохиолдолд дэлгүүрийн гэрээг цуцлах, хууль хяналтын байгууллагад хандан зөрчлийг арилгуулахыг ажлын хэсэг (Ж.Оюунгэрэл), тайлан мэдээг холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Ё.Даариймаа)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100185

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 25 өдөр | Дугаар А/94 | Хужирт сум

Тээврийн хэрэгслийн албан татвар хураах,
техникийн хяналтын үзлэг явуулах,
жолоочийн даатгалд хамруулах тухай

Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, $19^1$ дүгээр зүйлийн $19^1.1$ дэх заалт, Аймгийн засаг даргын 2020 оны “Тээврийн хэрэгслийн албан татвар хураах, Техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийн даатгалд хамруулах тухай” А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд тээврийн хэрэгслийн 2020 оны техникийн хяналтын үзлэг явуулах ажлын бэлтгэлийг хангуулах, зохион байгуулах салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч: Ж.Оюунгэрэл - Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: Б.Цэрэннадмид - Татварын Улсын байцаагч
Гишүүд: Х.Түмэнбаяр - Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа
Э.Бямбацэрэн - Хэсгийн төлөөлөгч, ахмад
Ц.Баарваань - Хэв журмын цагдаа, ахлагч
Б.Пагамдулам -1 дүгээр багийн Засаг дарга
Д.Батбаяр - 2 дугаар багийн Засаг дарга
Д.Галиндэв - 3 дугаар багийн Засаг дарга
Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга
Ц.Лхамролом - 5 дугаар багийн Засаг дарга
Ц.Амгалан - 6 дугаар багийн Засаг дарга

2. Авто техникийн үзлэгийг 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 6 дугаар сарын 07-ны өдөр хүртэлх хугацаанд тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулж ажиллахыг Комиссын ахлагч (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250120183

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/95 Хужирт сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг
дахин сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах, журам батлах тухай” 188 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 188 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан сумын хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасугай.

2. Хүнсний дэлгүүр болон архи, согтууруулах ундаа түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл оройн $20^{00}$ цаг байхаар хязгаарлалт тогтоон өөрчилж, караоке, баар, цэнгээний газруудын үйл ажиллагааг дээрх хугацаанд түр зогсоосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай” А/84 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

4. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Оюунгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100183

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 06 сарын 03 өдөр Дугаар А/96 Хужирт сум

### Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын харъяат Монгол Улсын Гавьяат Жүжигчин асан Долгорын Баттөмөрийн ар гэрт 300000 (гурван зуун мянган) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250190189

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 03 өдөр Дугаар А/97 Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт тухай” 15/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 5 дугаар багийн нутаг, Гуа, Ананд сувилалын урд талд байрлах 3500 $м^2$ газрыг Өвөрхангай аймгийн “Онцгой байдлын газарт (9045058) эрэн хайх, аврах бүлгийн байр болон сургалтын талбай байгуулах зориулалтаар 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан, төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100193

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
# ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 08 өдөр Дугаар А/98 Хужирт сум

## Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр баг хаягт оршин суух Лэгшидийн Мэндбаяр (ЙС74041614) нь өөрийн эзэмшлийн 4 дүгээр баг Шунхлай 26 тоотод байрлах 000004898 гэрчилгээний дугаартай, 6211003908 нэгж талбарын дугаартай "Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор"-ын зориулалттай 3684.0 $м^2$ газраас хавсралтанд заасан нэр бүхий 6 иргэнд нийт 655 $м^2$ газрыг шилжүүлсэн тул дээрх газрыг "Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор"-ын зориулалтаар 39 жил 5 сарын хугацаатайгаар нэр бүхий 6 иргэнд эзэмшүүлсүгэй.

2. Дээрх 3684 $м^2$ газраас 443 $м^2$ газар нь нийтийн эзэмшлийн зам талбайн орц, гарц таарч байгаа тул нийтийн эзэмшилд шилжүүлж үлдсэн 2586 $м^2$ газарт газар эзэмших эрхийн гэрчилгээг шинээр олгосугай.

3. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100185

Хужирт сумын Засаг даргын 2020 оны
06 дугаар сарын 08 -ний өдрийн А/98
захирамжийн хавсралт

Газар эзэмших эрх шилжүүлэн авч буй иргэдийн нэрсийн жагсаалт

| д/д | Газар эзэмшигчийн | | | Эзэмшсэн газрын | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Эцэг /эх/-ийн нэр | Өөрийн нэр | Регистрийн дугаар | Байршил хаяг | Зориулалт | Хэмжээ /м²/ |
| 1 | Цэнд | Уламбаяр | ЙС80032601 | Хужирт 4- баг Шивээт 26 тоот | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор | 17 |
| 2 | Цэрэндулам | Батчулуун | ЙС75012918 | | | 37 |
| 3 | Лхүндэв | Мандахбаяр | ЙЕ85051030 | | | 35 |
| 4 | Баатар | Ариунаа | ЙС75122905 | | | 140 |
| 5 | Лэгшид | Зориг | ЙС72062231 | | | 350 |
| 6 | Дамдинсүрэн | Даваасүрэн | ЙС99062419 | | | 76 |
| Нийт | | | | | | 655 |

-oOo-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 08 өдөр Дугаар А/99 Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн $7^1$ дугаар зүйлийн $7^1$.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх "Гэрэлтүүлэг засвар ӨВХУСЗДТГ/202001020" ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Мөнхбат - Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд: Ц.Нямдорж - Газрын даамал
С.Самдан - Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

250100197